

Захиалагч: Глоб Интернэйшнл ТББ

Бэлтгэсэн: Р.Оюунцэцэг, ХХ-гийн дэргэдэх “Сэтгүүлч” коллежийн гүйцэтгэх захирал

Бэлэн болгох хугацаа: 2007 оны 9 дүгээр сарын 29 нөөс 10 дугаар сарын 5

Хэмжээ: 5-10 хх /А4, 12 фонт/

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ НЬ

/Гарын авлага: онол, практикийн тайлбар/

1. Сэтгүүл зүйн эх сурвалж, түүний төрөл, түвшин, ашиглах арга зам
2. Нууц эх сурвалж, түүнтэй харьцах, хамгаалах арга зам
3. Эх сурвалжтай ажиллах практик зөвлөмж
4. Ном зүй

Сэтгүүл зүйн эх сурвалж, түүний төрөл ба түвшин, ашиглах арга зам

Нэг. Судалгаа ба эх сурвалж.

Сэтгүүл зүй нь бүхэлдээ баримтын эрэл, түүнийг мэргэжлийн түвшинд бүрдүүлж боловсруулах судалгаа юм. Сэтгүүлч эдгээр баримтыг хий хоосон зүйлээс гаргаж ирдэггүй бөгөөд судалгаа, сурвалжлага хийх явцдаа тэрээр олж мэдсэн, сонсож дуулсан эсвэл үзэж харсандаа тулгуурлан сэтгүүл зүйн бүтээл туурвидаг. Тэрхүү баримт мэдээллийн аливаа эх үүсвэр нь сэтгүүл зүйн эх сурвалж гэсэн ойлголтод хамрагдана.

Хоёр. Эх сурвалжийн төрөл, түвшин.

Эх сурвалжийн үндсэн гурван төрөл байна. Үүнд:

- Аман эх сурвалж /хэн нэгэнтэй ярилцах замаар мэдээлэл олж авах хэлбэр: хэн нэг хүний амнаас сонссон ярианаас авахуулаад албан ёсны ярилцлага хүртэл багтана/,
- Бичгийн эх сурвалж /сэтгүүлчийн судалсан болон ашигласан хэвлэмэл болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжиж ирсэн баримт мэдээллүүд: бүх төрлийн бичиг баримт түүхэн сурвалжаас авахуулаад албан бичиг, статистик мэдээ, ном судар, сурах бичиг, шинжлэх ухааны баримт, тайлан мэдээлэл, хууль тогтоомж, ОНМХ, төрөл бүрийн мэдээллийн хуудас, дуу дүрс бичлэг гэх мэт/,
- Ажиглалт /сэтгүүлч өөрийн ажиглалтаар олж тогтоосон мэдээлэл, баримтууд/ зэрэг багтана.

Аман эх сурвалжийн мэдээллийг үнэлж цэгнэх үнэлэмжийн түвшингээр нь гурав ангилна. Тухайлбал:

- Мэргэжилтний түвшин /тухайн асуудлыг хөндлөнгийн, мэргэжилтний байр сууринаас хандан тайлбарлана: эрдэмтэн, судлаач, бие даасан ажиглагч, шинжээч, их сургуулийн багш, зохиолч гэх мэт/,

- Сонирхлын түвшин /тухайн асуудалд аливаа эрх ашгийн үүднээс хандаж, тухайн эрх ашгийг хамгаалсан байр суурь илэрхийлнэ: улс төрч, албан тушаалтан, бизнес эрхлэгч, иргэний хөдөлгөөний төлөөлөгч гэх мэт/,
- Үр дагаврыг хүртэгсдийн түвшин /тухайн асуудалд шууд хамаатай, эрх ашиг нь хөндөгдөн хохирсон тал: хадгаламж зээлийн хоршоодын хохирогч, амь насаа алдсан аврагчид, тэдгээрийн аль алиных нь ар гэр гэх мэт/ зэрэг болно.

Гурав. Эх сурвалжийг ашиглах арга зам.

Эх сурвалжийн аль нэг төрөл ба түвшний мэдээлэл, баримт нь дангаараа сэтгүүл зүйн хөдөлшгүй баримт болох нь ховор. Тухайн мэдээлэл, баримтыг өөр бусад төрөл, түвшний, өөрөөр хэлбэл бие биеэсээ тусгаар орших эх сурвалжуудын мэдээлэл, баримтаар баяжуулж, баталгаажуулах нь чухал. Тиймээс тодорхой эх сурвалжаас авсан мэдээлэлд нягт нямбай, няхуур хянамгай, шүүмжлэлтэй хандах, тэгснээр мэдээллийг тэнцвэржүүлэх боломж бүрддэг.

Аль ч тохиолдолд эх сурвалжийг нэр зааж дурьдах нь сэтгүүл зүйн үндсэн шаардлагуудын нэг бөгөөд энэхүү бодлого нь дараахь ач холбогдолтой юм. Энэ нь нэгдүгээрт, мэдээллийн бодит чанарыг дээшлүүлдэг /тухайн сурвалжлагч ажлаа зөв хийснийг буюу зөв хүнийг олж уулзаад, уншигчдаа зөв мэдээлэл авч өгснийг тодруулж өгнө/, хоёрдугаарт, уншигчдад итгэл үнэмшил төрүүлдэг /олон нийтийн хэлэлцүүлгийг хүлээх чадвартай эх сурвалж сэтгүүлчийн материалыг илүү хүчтэй, чанартай болгоно/, гуравдугаарт, сэтгүүлчийн болон мэдээллийн хэрэгслийн хариуцлагыг сайжруулдаг.

Тэгвэл нэр дурдалгүй эх сурвалж ашигласан тохиолдол нь ХМБ-ыг мэргэжлийн түвшинд ажиллаж чадахгүй байгаагийн наад захын илрэл болж, тухайн сэтгүүлч болон ХМБ-ыг эрсдэлд оруулах магадлалыг ихэсгэж байна. Угаас эх сурвалжийг байнга нууцлах нь тухайн хэвлэл, мэдээллийн байгууллага хүмүүсийн итгэх итгэлийг сулруулахаас гадна сурвалжлагч, эх сурвалжийн аль алинд муу зуршил бий болгодог. Монголын сэтгүүл зүйн практикт “баттай эх сурвалж” гэсэн нэрийн дор эх сурвалжийг дурдалгүй өнгөрөх үзэгдэл түгээмэл байдаг. Ихэвчлэн таамаг төдий зүйлд тулгуурласан юм уу, эсвэл сөрөг мэдээлэл өгч буй хүн нэрээ нууцлахыг хүсдэг бөгөөд тэр мэдээллийг зарим тохиолдолд батлах боломжгүй байдгийг үл харгалзан сэтгүүлчид үүнийг ашигладаг. Тиймээс нэргүй эх сурвалж ашиглах эсэхээ сурвалжлагч болон хэвлэл, мэдээллийн байгууллага сайтар тунгаан бодож, нууцлах шаардлагагүй нөхцөлд эх сурвалжийг дурьдах нэгдсэн шаардлагыг мөрдөх нь зүйн хэрэг. Нөгөөтэйгүүр, ОНМХ-д нийтэлж, нэвтрүүлсэн аливаа зүйлийн хариуцлагыг сэтгүүлч, редактор эсвэл тухайн хэрэгсэл өөрөө хүлээх зарчим ардчилсан

улс орнуудад үйлчилдэг ч манайд энэ талаар буруу ойлголт тогтсон байдаг. Юу гэвэл, эх сурвалжийн нэр заах нь тухайн мэдээллийн хариуцлагыг түүнд шилжүүлэн хүлээлгэж буй асуудал мэтээр ойлгож, үүнийгээ бүр ил тод өөрийн хэрэгслээрээ зарлан тунхагладаг.

Нууц эх сурвалж, түүнтэй харьцах, түүнийг хамгаалах арга зам

Нэг. Нууц эх сурвалж, түүнтэй харьцах.

Энэ нь нэргүй бөгөөд нэрээ дурьдуулах сонирхолгүй эх сурвалжаас харьцангуй өөр ойлголт юм. Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргаснаар тухайн эх сурвалжийн ажил, амьдрал, гэр бүл эрсдэхээс сэргийлж сэтгүүлч, ХМБ тухайн эх сурвалжтай холбоотой /нэр ус, ажил албан тушаал зэрэг/ мэдээллийг зориудаар нууцлах тухай асуудал. Ийм эх сурвалжийг барууны сэтгүүл зүйд “шүгэл үлээгч” буюу “шүгэлдэгч” гэж нэрлэдэг бөгөөд тэд хэн ч /гол төлөв нууц мэдээлэл тээгч, түүнд ойр төрийн албан хаагч/ байж болно. Түүнийг ялгаж сурах нь сэтгүүлчийн ур чадвар, туршлагатай холбоотой гэж үздэг. Харин түүнийг нууцалж чадах эсэхээ тухайн сэтгүүлч, ХМБ эхнээсээ шударга хүлээх ёстой. “Шүгэл үлээгч” буюу нууц эх сурвалжаа хамгаалж сэтгүүлч өөрөө шоронд орсон тохиолдол гадаад оронд цөөнгүй бий.

Хоёр. Нууц / баттай эх сурвалжуудтай хэрхэн харьцаж, хамтран ажиллах вэ?

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр дагнаж буй сэтгүүлчид ихэнх тохиолдолд нууц мэдээний эх сурвалж болох хувь хүмүүсийн мэдээлэлд тулгуурлан судалгаа хийдэг. Гол төлөв нууц мэдээллийг тээгч тухайн хувь хүн сэтгүүлчийг өөрөө эрж олдог бөгөөд нууц мэдээллийг задруулснаараа тэд хууль дүрэм буюу тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ зөрчиж шийтгэл хүлээх эрсдэлд ордог учир өөрсдийгөө хамгаалах үүднээс нууц байхыг хүсдэг. Тийм учраас сэтгүүлчид нэг талаас мэргэжлийн ёс зүйн үүднээс мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзах, нөгөө талаас мэдээллийн эх сурвалжаа нууцалж чадсанаар цаашид тухайн эх сурвалжаас болон бусад мэдээлэл өгөх сонирхолтой эх сурвалжаас мэдээлэл авах үүд хаалгыг нээлттэй болгоно.

Нууц эх сурвалжтай харьцах, хамтран ажиллах тусгай жор байхгүй ч зарим орны эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн арга туршлагад тулгуурласан зарчмуудыг санал болгоё. Үүнд:

- Эх сурвалж болгон өөрийн үнэний хэмжүүртэйг сана. Сэтгүүлч хүн эх сурвалжийн бөгөөд өөрийн үнэний хэмжүүрийг даван харах чадвартай байх ёстой.
- Эх сурвалж зөвхөн өөрийн төлөө бус ар гэрийнхнийхээ төлөө санаа зовдог, тиймээс ч өөрийн тээж буй мэдээллийг ил гаргах эсэхдээ

үргэлж эргэлзэж байдаг. Хэнд ч бүрэн итгэдэггүй. Амьдрал, ажил төрлөөрөө дэнчин тавьдаг. Энэ тохиолдолд сэтгүүлч түүнийг ойлгож, хүндлэх нь зүйн хэрэг, түүнийг шахаж шавдуулалгүйгээр өөрөөр нь шийдвэр гаргуулах нь чухал.

- Эх сурвалж таныг сонгосон тохиолдолд итгэл өвөрлөсөн байдаг, аливаа жижиг сажиг зүйл, хандлагаар түүнийг нь хөсөрдүүлэхгүй байх, эхэн үедээ тэр сэтгэл санаагаа зүгээр хуваалцах зорилготой, үндсэн мэдээллийг хэлэхгүй байж болно. Тийм болохоор сэтгүүлч түүний итгэл найдварыг хүлээх чадвартайгаа харуулах ёстой.
- Сэтгүүлчийн хувьд эх сурвалжтай нүүр тулж уулзаж, өөрийгөө ойлгуулах нь юу юунаас чухал байдаг. Утасны цаанаас юм уу өөр бусад аргаар харилцахад эх сурвалж түүнийг өөрийг нь худалдахгүй гэх баталгаа найдвар төрдөггүй, тиймээс тухайн эх сурвалж сэтгүүлчид юу юунаас илүү чухал гэдгийг нүүр учирч байгаад хэлэх нь сэтгүүлчийн хувьд шударга хандлага болно.
- Мэдээлэл өгөх тохиолдолд тухайн мэдээллийн үнэн эсэхийг шалгах, худал хэлээгүйг тогтоох. Тэр тохиолдолд түүний аливаа болзлыг сэтгүүлч хүндэтгэн үзэх, бичлэг хийж болох эсэхийг эх сурвалжаасаа асуух ёстой.
- Асуудлаа ойлгуулах, түүний өгөх мэдээллийн ач холбогдлыг олон талаас ярих, чухал мэдээлэл өгснөөр олон мянган хүний эрх ашгийг хамгаална, шударга ёс тогтоно гэдгийг тайлбарлан таниулах нь сэтгүүлчийн үүрэг. Үүний дараа эцсийн шийдвэрийг эх сурвалж өөрөө гаргана гэдгийг дахин сануулах нь бас сэтгүүлчийн үүрэг байх ёстой.
- Зарим нэрээ нууцлах эсэхийг шийдэж чадахгүй байгаа эх сурвалжид түүний байр суурийг бусад хүмүүс мэдэх болно, өөрийгээ таниулна гэдгийг тайлбарлах, сэтгүүлчийн цаана ямар нэвтрүүлэг, ямар ХМБ байгааг хэлэх ёстой. Ингэснээр сэтгүүлч өөрийгээ найдвартай түнш гэдгээ харуулах боломжтой.
- Эх сурвалжтай мэргэжлийн түвшинд харьцах, хэт найзархахгүй, хуурч мэхлэх арга хэрэглэхгүй, гэхдээ өөрт хэрэгтэй мэдээллээ авна гэдгийг эх сурвалждаа ойлгуулах нь чухал зэрэг зарчим багтана.

Гурав. Нууц эх сурвалжийг хэрхэн хамгаалах вэ?

Нууц эх сурвалжийн болон нууц эх сурвалжтай ажиллаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн хамгаалалт нь тусдаа сэдэв тул энд зөвхөн сэтгүүлч, ХМБ-ын үйл ажиллагааны хүрээний асуудалд төвлөрө.

Сэтгүүлчийн хувьд эх сурвалжаа хамгаалах арга замууд:

- Нууц эх сурвалжийн тухай мэдээллийг алдагдуулахгүйн тулд тэдгээрийг өөрт ойлгомжтойгоор кодлох,
- Мэдээлэл тус бүрийг хувиалан хадгалах,

- Эх сурвалжтай харилцах үед нууцлалын хэд хэдэн үе шатыг анхаарах. Үүнд: бичлэг хийхгүй байх, тодруулга хийхгүй байх зэрэг янз бүрээр нэрлэж хэвшсэн ойлголтууд энд ордог.
- Тухайн эх сурвалж ямар зорилгоор, яагаад мэдээлэл өгөх болсныг асуу, тэгснээр түүнийг болон өөрийгээ давхар хамгаална /Мэдээлэл өгөгч гомдолтой эсвэл шударга хүмүүсийн цаана нөгөө талын хүмүүсийн нэр төрийн асуудал байдаг/
- Тухайн асуудалтай шууд холбоогүй эх сурвалж олсноор гол эх сурвалжийг халхлах
- Хэлсэн зүйлийг нь ашиглахдаа албан тушаалыг нь ойртуулан, нэрийг нь хэлэхгүй өнгөрөх талаар өөртэй нь тохирох
- Эх сурвалжид хуульчийн зөвөлгөө өгүүлэх
- Эх сурвалждаа үнэнч бай. Хэлснийг нь бүү гуйвуул. Зөв иш тат, нууцална гэдгээ амла
- Сэтгүүлч хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд эх сурвалжаа хамгаална, шаардлагатай тохиолдолд хуулийн өмнө хариуцлага хүлээхэд бэлэн гэдгээ харуул

ХМБ-ын хувьд эх сурвалжийг хамгаалах аргууд:

- Өөрийн байгууллагын болон сэтгүүлчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчмын хүрээнд эх сурвалжаа хамгаалах тухай заалтыг тодорхой тусгаж, түүнийгээ мөрдлөг болгож хэвшүүлэх
- Мэргэжлийн болон эрх зүйн хүрээнд эх сурвалжаа хамгаалахад туштай тэмцэж чадахаа илэрхийлэх

Эх сурвалжтай ажиллах нийтлэг практик зөвлөмж

Эх сурвалжтай итгэлцлийн харилцаа тогтооно гэдэг урт хугацааны ажил бөгөөд үүнд хэдэн жил ч шаардагдаж мэднэ. Тэр хүмүүсийн заримынх нь нэр сонины хуудаснаа хэзээ ч дурсагдахгүй байж болно. Харин тэднээс олж авсан мэдээлэл ирээдүйн бүтээлийн сэдэл болж өгнө. Тиймээс,

- Өнөөдрөөс эхлэн ирээдүйд хамтын ажиллагаа хөгжүүлж болох хүмүүсээ таньж мэдэх хэрэгтэй болохоор өөрийн эх сурвалжийн сүлжээ бий болгох, тэдний талаархи шаардлагатай мэдээллийн бааз үүсгэ.
- Уулзсан эх сурвалж болгоноосоо тухайн мэдээллийн талаар эсвэл өөр хэрэгтэй шинэ мэдээллийг өөр хэнээс авч болохыг асууж байх, дараагийн эх сурвалжийг хэлүүл.
- Мэдээллийг баталгаажуулах талаар эх сурвалжаасаа үргэлж асуухаас гадна холбогдох баримтыг хаанаас олж авч болох тухай мэдэж ав.
- Мэдээллийг батлах бие даасан эх сурвалжуудын талаар эх сурвалжаасаа заавал тодруул, чухам тухайн асуудал, сэдвээр хэр зэрэг нэр хүндтэй, ач холбогдолтой, бие даасан мэргэжилтэн болохыг шалга.

- Эх сурвалжийн майнд мэл хийж багаар хэлэлцэх нь эх сурвалжуудыг орхигдуулахгүй байх, хамгийн чухал эх сурвалжийг олж авах зэрэгт хэрэгтэй.
- Сонин, хэвлэлийн хайчилбар, электрон мэдээллийн хэрэгслийн бичлэгүүд бусад аман эх сурвалжийг олоход тань хялбархан зуучилж өгнө.
- Эрх баригчид болон сөрөг хүчнийхний хоорондын маргаан сөргөлдөөнийг ашигла, та сөрөг хүчнийхэнтэй харилцаж хэрэгцээт мэдээлээ олж болох бөгөөд тэд танд мэдээлэл өгснөөрөө засгийн газрын нэр хүндийг унагаж байна гэж бодно.
- Түүнчлэн хувийн өрсөлдөгчид компаниуд болон дайсагнагч агентлагийн нэр хүндийг унагах сонирхолтой хувийн компани танд бизнесийн үйл ажиллагааны нууцын тухай мэдээлэл өгнө. Энэ мэтээр марган сөргөлдөгч талуудаас харилцан хандаж мэдээлэл олж авч болох юм.

Ном зүй

Люсинда С. Флисон, Эрэн сурвалжлах арван алхам, ОУ-ын сэтгүүлчдийн төв, Вашингтон, 2000

Тоби Мендель, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба эрэн сурвалжлах сэтгүүл зүй, гарын авлага

Мелвин Менчер, Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс, хоёрдугаар хэсэг, 88-97хх, Д.Цэмбэл, До.Цэнджав, Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практикийн асуудал, УБ., 2000

М.Зулькафиль, Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, УБ., 2002

ЮНЕСКО ба Хил хязгааргүй сурвалжлагчид, Сэтгүүлчдэд туслах зөвлөмж, 2002

Ч.Базар, Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ?, УБ., 2003

Зориг сан, Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчдийн нөр их хөдөлмөр, Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, УБ., 2004

Ронан Бради, Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах нь, Европын сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний бүлгүүдэд зориулсан гарын авлага, УБ, 2005

Ж.Батбаатар, Сэтгүүл зүй, УБ, 2007